**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/250/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 327734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Аудитор: Д.Баасанням<br>Утас: 325093 Цахим хаяг: baasannyamd@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 771

танай ________ -ны № ________ -т

БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Ц.БОЛД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар залруулагдаагүй 985.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/20 дугаар тогтоолоор үүсгэн байгуулсан байна. Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс үйл ажиллагааны зардалд шаардагдах 1,516.6 сая төгрөгийг олгож, өөрийн үйл ажиллагааны орлогоос 3,329.6 сая төгрөгийг бүрдүүлж, нийт 4,349.1 сая төгрөгийг зарцуулж, 595.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.
Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

1426050895

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1033 дугаар захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах, ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон орон сууцны 207 дугаар барилгыг буулгах ажлыг 2,463.2 сая төгрөгийн төсөвтэйгээр хийж гүйцэтгэсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 4 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 84.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үндсэн код | Үлдэгдэл | |
|---|---|---|---|---|
| | | | 1 сарын 1 | 12 сарын 31 |
| | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | | 426,005,126.26 |
| **1.1** | **Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө** | | **-** | **232,643,618.40** |
| 1.1.1 | Мөнгөн хөрөнгө | | - | 232,643,618.40 |
| 1.1.5 | Мастер карт | 10010400 | - | 182,305.96 |
| 1.1.6 | Дансан дахь мөнгө-ХХБ-415152000 | 11010100 | - | 68,347,312.44 |
| 1.1.7 | Дансан дахь мөнгө-ХААН банк-5171824277 | 11010200 | - | 164,114,000.00 |
| 1.2 | Татвар, НДШ-ийн авлага | | - | - |
| 1.2.1 | Татварын авлага | | - | - |
| 1.2.2 | ХЧТА | 12160000 | - | - |
| **1.3** | **Бусад авлага** | | **-** | **5,969,306.78** |
| 1.3.1 | Дансны авлага | | - | 5,969,306.78 |
| 1.3.2 | ААХ-аас авах авлага | 12210000 | - | 5,969,306.78 |
| 1.3.3 | Бусад авлага | 12410000 | - | - |
| 1.3.4 | Петровис карт | 12410100 | - | - |
| **1.4** | **Бараа материал** | | **-** | **186,568,566.60** |
| 1.4.1 | Бараа материал | | - | 186,568,566.60 |
| 1.4.2 | Бичиг хэргийн материал | 14010100 | - | 168,300.00 |
| 1.4.3 | Аж ахуйн материал | 14010200 | - | 16,492,763.34 |
| 1.4.4 | Шатахуун, шатах тослох материал | 14010300 | - | 22,751,026.86 |
| 1.4.5 | Сэлбэг хэрэгсэл | 14010400 | - | 52,186,254.69 |
| 1.4.6 | Хангамжийн материал | 14011000 | - | 94,970,221.71 |
| **1.5** | **Урьдчилж төлсөн зардал/тооцоо** | | **-** | **823,634.48** |
| 1.5.1 | УТЗ | | - | 823,634.48 |
| 1.5.2 | Урьдчилж гарсан зардал | 15010000 | - | 823,634.48 |
| 1.5.3 | Цалингийн урьдчилгаа | 15160000 | - | - |
| 1.5.4 | Шатахууны тооцоо | 15170000 | - | - |
| 1.5.5 | Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа | 15180000 | - | - |
| **1.6** | **Үндсэн хөрөнгө** | | **-** | **170,013,491.86** |
| 1.6.1 | Үндсэн хөрөнгө | | - | 170,013,491.86 |
| 1.6.2 | Тээврийн хэрэгсэл | 20020000 | - | 21,141,250.00 |
| 1.6.3 | Компьютер | 20030000 | - | 50,765,550.00 |
| 1.6.4 | Тоног төхөөрөмж | 20030100 | - | 37,346,339.00 |
| 1.6.5 | Тавилга, эд хошил | 20040000 | - | 81,482,100.00 |
| 1.6.6 | Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл | 20220000 | - | 266,666.66 |
| 1.6.7 | Хуримтлагдсан элэгдэл-Компьютер | 20230000 | - | 8,007,328.06 |
| 1.6.8 | Хуримтлагдсан элэгдэл-Тоног төхөөрөмж | 20230100 | - | 4,070,146.92 |
| 1.6.9 | Хуримтлагдсан элэгдэл-Тавилга, эд хогшил | 20240000 | - | 8,377,605.50 |
| **1.7** | **1.2.02 Биет бус хөрөнгө** | | **-** | **1,388,666.65** |
| 1.7.1 | Биет бус хөрөнгө | | - | 1,388,666.65 |
| 1.7.2 | Компьютерийн программ хангамж | 21060000 | - | 3,194,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.7.3 | Програм хангамжийн хуримтлагдсан элэгдэл | 21260000 | - | 1,805,333.35 |
| 1.7.4 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | - | **597,407,284.77** |
| 1.8 | Дансны өглөг | | - | - |
| 1.8.1 | Байгууллагуудад өгөх өглөг | 31010000 | - | - |
| 1.8.2 | Бусад өглөг | 31810000 | - | - |
| 1.8.3 | Цалингийн өглөг | | - | - |
| 1.8.4 | Цалингийн өглөг | 33010000 | - | - |
| 1.8.5 | Татварын өр | | - | 53,900,756.81 |
| 1.8.6 | Байгууллагын ОрАлТат-ын өглөг | 34010000 | - | - |
| 1.8.7 | ХХОАТ-ын өглөг | 34030000 | - | 53,900,756.81 |
| 1.8.8 | НДШ - ийн өглөг | | - | 46,344,067.13 |
| 1.8.9 | НДШ,ЭМД-ын өглөг | 34110000 | - | 46,344,067.13 |
| 1.9 | Тайлангийн үеийн ашиг | | - | 497,162,460.83 |
| 1.9.1 | Тайлант үеийн ашиг, алдагдал | 46020000 | - | 497,162,460.83 |
| 1.9.2 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН** | | **-** | **597,407,284.77** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Үндсэн код | 12 сарын 31 үлдэгдэл |
|---|---|---|
| **Орлого** | | **4,846,916,756.93** |
| Татаас саннхүүжилтийн орлого | 51000000 | 1,516,634,100.00 |
| Борлуулалтын орлого | 51010000 | 3,327,638,343.00 |
| Хүүгийн орлого | 51050000 | 2,409,993.45 |
| Картын хөнгөлөлтийн орлого | 51060000 | 234,320.48 |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | | **4,846,916,756.93** |
| Мөнгөн хөрөнгө | | 2,597,550.00 |
| Даатгалын зардал - Авто бааз | 61101202 | 1,097,550.00 |
| Даатгалын зардал - Удирдлага | 70101101 | 1,500,000.00 |
| Дансны авлага | | 192,970,673.34 |
| Сэлбэг хэрэгсэл - Авто бааз | 61121202 | 62,389,554.28 |
| Урсгал засвар - Авто бааз | 61122202 | 62,500.00 |
| Засварын үйлчилгээний хөлс - Авто бааз | 61123202 | 8,532,560.00 |
| Сэлбэг хэрэгсэл - Удирдлага | 70121101 | 17,765,968.40 |
| Сэлбэг хэрэгсэл - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70121102 | 350,000.00 |
| Сэлбэг хэрэгсэл - Аж ахуйн хэсэг | 70121104 | 4,367,600.00 |
| Урсгал засвар - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70122102 | 17,653,093.00 |
| Засварын үйлчилгээний хөлс - Удирдлага | 70123101 | 17,302,397.66 |
| Засварын үйлчилгээний хөлс - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70123102 | 64,547,000.00 |
| Бараа материал | | 263,611,975.00 |
| Түрээсийн зардал-Орон сууц - Авто бааз | 61141202 | 55,350,000.00 |
| Түрээсийн зардал-Тоног төхөөрөмж - Авто бааз | 61142202 | 31,462,710.00 |
| Түрээсийн зардал-Тээврийн хэрэгсэл - Инженер техникийн нэгж | 61143201 | 360,000.00 |

| | | |
|---|---|---|
| Түрээсийн зардал-Тээврийн хэрэгсэл - Авто бааз | 61143202 | 80,000.00 |
| Түрээсийн зардал-Орон сууц - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70141102 | 2,000,000.00 |
| Түрээсийн зардал-Тоног төхөөрөмж - Удирдлага | 70142101 | 116,050,000.00 |
| Түрээсийн зардал-Тоног төхөөрөмж - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70142102 | 2,279,330.00 |
| Түрээсийн зардал-Тээврийн хэрэгсэл - Удирдлага | 70143101 | 53,200,435.00 |
| Түрээсийн зардал-Тээврийн хэрэгсэл - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70143102 | 2,829,500.00 |
| УТЗ | | 55,581,817.00 |
| Харуул хамгаалалтын зардал - Удирдлага | 70151101 | 55,581,817.00 |
| Татварын авлага | | 22,527,080.49 |
| Элэгдлийн зардал - Инженер техникийн нэгж | 61131201 | 3,596,629.28 |
| Элэгдлийн зардал - Авто бааз | 61131202 | 604,416.62 |
| Элэгдлийн зардал - Удирдлага | 70131101 | 2,147,916.60 |
| Элэгдлийн зардал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70131102 | 7,619,516.88 |
| Элэгдлийн зардал - Санхүү бүртгэлийн нэгж | 70131103 | 5,953,432.13 |
| Элэгдлийн зардал - Аж ахуйн хэсэг | 70131104 | 2,605,168.98 |
| Үндсэн хөрөнгө | | 70,021,763.65 |
| Хоол хүнсний зардал - Авто бааз | 61201202 | 26,061,923.45 |
| Хоол хүнсний зардал - Удирдлага | 70201101 | 8,928,513.54 |
| Хоол хүнсний зардал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70201102 | 11,030,304.66 |
| Хоол хүнсний зардал - Санхүү бүртгэлийн нэгж | 70201103 | 436,420.00 |
| Хоол хүнсний зардал - Аж ахуйн хэсэг | 70201104 | 23,564,602.00 |
| Бусад | | 1,712,072,345.00 |
| Бусад зардал - Удирдлага | 70221101 | 1,709,572,345.00 |
| Бусад зардал - Аж ахуйн хэсэг | 70221104 | 2,500,000.00 |
| Биет бус хөрөнгө | | 11,116,370.00 |
| Ажлын хувцас, хэрэгсэл - Инженер техникийн нэгж | 61211201 | 726,000.00 |
| Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл – Авто бааз | 61212202 | 236,380.00 |
| Ажлын хувцас, хэрэгсэл - Удирдлага | 70211101 | 4,752,000.00 |
| Ажлын хувцас, хэрэгсэл - Аж ахуйн хэсэг | 70211104 | 523,000.00 |
| Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл - Аж ахуйн хэсэг | 70212104 | 4,878,990.00 |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | | 1,195,823,937.58 |
| Үндсэн цалин - Удирдлага | 70011101 | 1,195,823,937.58 |
| НДШ-ийн зардал | | 129,756,248.01 |
| НДШ, ЭМД-н зардал - Удирдлага | 70021101 | 129,756,248.01 |
| Ашиглалтын зардал | | 80,180,728.58 |
| Цахилгаан – Авто бааз | 61111202 | 42,424,823.00 |
| Цахилгаан - Удирдлага | 70111101 | 35,045,138.63 |
| Цахилгаан - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70111102 | 13,750.00 |
| Цахилгаан - Санхүү бүртгэлийн нэгж | 70111103 | 385,100.00 |
| Дулаан - Удирдлага | 70112101 | 542,386.95 |
| Дулаан - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70112102 | 164,230.00 |
| Хэрэглээний цэвэр ус - Удирдлага | 70113101 | 1,400,000.00 |

| | | |
|---|---|---|
| Хэрэглээний цэвэр ус - Аж ахуйн хэсэг | 70113104 | 75,300.00 |
| Газын хэрэглээ - Удирдлага | 70114101 | 130,000.00 |
| Бичиг хэргийн зардал | | 8,882,360.00 |
| Бичиг хэргийн зардал - Авто бааз | 61051202 | 167,300.00 |
| Бичиг хэргийн зардал - Удирдлага | 70051101 | 4,381,437.04 |
| Бичиг хэргийн зардал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70051102 | 1,813,303.18 |
| Бичиг хэргийн зардал - Аж ахуйн хэсэг | 70051104 | 2,401,119.78 |
| Бичиг хэргийн хэрэгсэл - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70052102 | 119,200.00 |
| Шатахууны зардал | | 432,036,219.14 |
| Тээвэр шатахуун - Инженер техникийн нэгж | 61181201 | 40,000.00 |
| Тээвэр шатахуун - Авто бааз | 61181202 | 184,701,760.00 |
| Тос тосолгооны үйлчилгээ - Авто бааз | 61183202 | 5,607,200.00 |
| Шатах тослох материал /бааз/ | 61221203 | 16,449,673.14 |
| Тээвэр шатахуун - Удирдлага | 70181101 | 222,128,170.00 |
| Тээвэр шатахуун - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70181102 | 973,738.00 |
| Тээвэр шатахуун - Санхүү бүртгэлийн нэгж | 70181103 | 699,457.00 |
| Тээвэр шатахуун - Аж ахуйн хэсэг | 70181104 | 1,254,221.00 |
| Тос тосолгооны үйлчилгээ - Удирдлага | 70183101 | 138,000.00 |
| Тос тосолгооны үйлчилгээ - Аж ахуйн хэсэг | 70183104 | 44,000.00 |
| Шуудан холбооны зардал | | 5,150,028.00 |
| Утасны төлбөр - Авто бааз | 61061202 | 301,472.00 |
| Утасны төлбөр - Удирдлага | 70061101 | 112,654.00 |
| Утасны төлбөр - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70061102 | 323,000.00 |
| Интернетийн төлбөр - Удирдлага | 70062101 | 4,412,902.00 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | | 434,601.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ - Удирдлага | 70071101 | 195,800.00 |
| Банкны шимтгэл - Санхүү бүртгэлийн нэгж | 70073103 | 238,801.00 |
| Сонин сэтгүүл захиалгын зардал | | 4,669,980.00 |
| Хэвлэл захиалга - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70091102 | 213,800.00 |
| Хэвлэл мэдээллийн зардал - Удирдлага | 70092101 | 4,456,180.00 |
| Томилолтын зардал | | 4,147,344.00 |
| Гадаад албан томилолт - Удирдлага | 70042101 | 4,147,344.00 |
| Сургалтын зардал | | 4,425,000.00 |
| Сургалтын зардал – Авто бааз | 61081202 | 500,000.00 |
| Сургалтын зардал - Удирдлага | 70081101 | 2,875,000.00 |
| Сургалтын зардал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70081102 | 1,050,000.00 |
| Нийгмийн арга хэмжээний зардал | | 46,281,163.56 |
| Буцалтгүй тусламж – Авто бааз | 61193202 | 1,500,000.00 |
| Буцалтгүй тусламж - Удирдлага | 70193101 | 160,000.00 |
| Буцалтгүй тусламж - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70193102 | 44,301,163.56 |
| Буцалтгүй тусламж - Санхүү бүртгэлийн нэгж | 70193103 | 320,000.00 |
| Албан татвар, төлбөр хураамжийн зардал | | 7,297,000.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо - Инженер техникийн нэгж | 61032201 | 3,873,000.00 |

| | | |
|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо - Авто бааз | 61032202 | 2,500,000.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо - Удирдлага | 70032101 | 426,200.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70032102 | 459,800.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо - Санхүү бүртгэлийн нэгж | 70032103 | 34,00.00 |
| Замын хураамж - Удирдлага | 70035101 | 4,000.00 |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | | 92,838,018.82 |
| Цэвэрлэгээний материал - Инженер техникийн нэгж | 61161201 | 614,400.00 |
| Цэвэрлэгээний материал - Авто бааз | 61161202 | 3,119,200.00 |
| Аж ахуйн материал - Инженер техникийн нэгж | 61162201 | 6,095,329.99 |
| Аж ахуйн материал - Авто бааз | 61162202 | 45,495,297.36 |
| Цэвэрлэгээний материал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70161102 | 20,323,000.00 |
| Аж ахуйн материал - Захиргаа хүний нөөцийн нэгж | 70162102 | 4,320,283.50 |
| Аж ахуйн материал - Санхүү бүртгэлийн нэгж | 70162103 | 395,460.00 |
| Аж ахуйн материал - Аж ахуйн хэсэг | 70162104 | 12,475,047.97 |
| ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | 4,342,422,203.17 |
| ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ) | | 504,494,553.76 |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | | - |
| Үйл ажиллагааны бус зардал | | 5,181,245.00 |
| Бусад зардал | 74050000 | 5,131,245.00 |
| Торгууль хөнгөлөлтийн алдагдал | 74070000 | 50,000.00 |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | 5,181,245.00 |
| ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ) | | (5,181,245.00) |
| ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ) | | 499,313,308.76 |
| ОАТЗ | | 2,150,847.93 |
| Орлогын албан татварын зардал | 91010000 | 1,962,583.84 |
| Хүүгийн ОАТ | 91020000 | 188,264.09 |
| ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ) | | 497,162,460.83 |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | - | - |
| 2 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | - | - |
| 3 | Залруулсан үлдэгдэл | - | - |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - |
| 9 | 2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө,алдааны залруулга | - | - |
| 11 | Залруулсан үлдэгдэл | - | - |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 497,162,460.83 | 497,162,460.83 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - |
| 17 | 2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл | 497,162,460.83 | 497,162,460.83 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **4,846,220,688.00** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | - | 3,327,638,343.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | - | 1,516,634,100.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | - | 1,948,245.00 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **4,234,874,638.37** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | - | 995,761,005.34 |
| 1/2/2002 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | - | 196,899,341.32 |
| 1/2/2003 | Бараа материал худалдан авахад төлсөн | - | 279,538,429.64 |
| 1/2/2004 | Ашиглалтын зардалд төлсөн | - | 137,089,213.63 |
| 1/2/2005 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | 2,444,622,348.06 |
| 1/2/2006 | Хүүний төлбөрт төлсөн | - | 223,469.52 |
| 1/2/2007 | Татварын байгууллагад төлсөн | - | 50,644,066.77 |
| 1/2/2008 | Даатгалын төлбөрт төлсөн | - | 4,983,598.60 |
| 1/2/2009 | Бусад мөнгөн зарлага | - | 125,113,165.49 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-** | **611,346,049.63** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **2,234,695.33** |
| 2/1/2006 | Хүлээн авсан хүүний орлого | - | 2,234,695.33 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **381,337,126.56** |
| **2.2.1** | **Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн** | **-** | **245,120,099.00** |
| 2/2/2002 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 3,194,000.00 |
| 2/2/2006 | Бусад | - | 133,023,027.56 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-** | **(379,102,431.23)** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **1,126,489,400.00** |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 1,126,489,400.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | - | 1,126,489,400.00 |
| 3.2.1 | Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | 1,126,489,400.00 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | - | 232,243,618.40 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 232,243,618.40 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 985,600.4 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 59,020.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 955,135.2 төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт 1.* Анхан шатны дэмжих, нотлох баримтгүйгээр 28,322.3 мянган төгрөгийн гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны дэмжин нотлох баримтгүй гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан зөрчлийн 28,322.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Байгууллагын оффисын ажилчдад 2,142.9 мянган төгрөгийн хувцас худалдан авч төлбөрийг төсвөөс төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *"Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно"* гэж заасантай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь*** Байгууллагын оффисын ажилчдад хувцас худалдан авсан 2,142.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Зөвлөмж

1. Анхан шатны бүрдэл дутуу 141,389.8 мянган төгрөгийн баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээг дүгнэсэн акт үйлдэж байх

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулалгүйгээр төсөвт өртгийг хуваан 469,451.8 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Бараа материалын дансаар дамжуулалгүй 344,293.6 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Байгууллагын хөрөнгөөр худалдаж авсан бараа, материалыг орлогод авч байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан. | 1 | 28,322.3 | 1 | 28,322.30 | | | | |
| Байгууллагын оффисын ажилчдад хувцас худалдаж авч төлбөрийг төсвөөс төлсөн байна. | 1 | 2,142.9 | 1 | 2,142.9 | | | | |
| Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан. | 1 | 141,389.8 | | | | | 1 | 141,389.8 |
| Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулалгүйгээр төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 469,451.8 | | | | | 1 | 469,451.8 |
| Бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн байх | 1 | 344,293.6 | | | | | 1 | 344,293.6 |
| **Нийт дүн** | **5** | **985,600.4** | **2** | **30,465.2** | | | **3** | **955,135.2** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хууль | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийн системд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,062,251.7 мянган төгрөгийн зарлагын 170 гүйлгээг тус мэдээлээгүй байна. | 1 | 6,062,251.7 | | | | | 1 | 6,062,251.7 |
| **Нийт дүн** | **1** | **6,062,251.7** | | | | | **1** | **6,062,251.7** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллагын тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ОНӨТҮГ | 1 | 1 | | | | 1 | | |
| | Нийт | 1 | 1 | | | | 1 | | |